



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 4/598

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Монгол абилимп- 2025” мэргэжлийн ур чадварын улсын уралдаанд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохион байгуулж оролцуулах зардалд 965,000 (есөн зуун жаран таван мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

